

Адуучин 2014 улсын уран уургач, бугуйлчдын тэмцээн

Ерөнхий сайдын ивээл дор жил бүр зохион байгуулдаг “Адуучин 2014” тэмцээн 2014 оны 8 дугаар сар 23-ний өдөр Хүй долоон худагт 21 аймгаас шалгарч ирсэн адуучид уурга ташуур шүүрэх, уран уургач, уран бугуйлч, эмнэг хангал сургагч гэсэн дөрвөн төрлөөр өрсөлдөж шилдгүүдээ тодрууллаа.

Монголчуудын адуу эдлэх соёлыг олон нийтэд түгээн сурталчлах, энэ соёлыг хадгалж хамгаалж үлдэх, эзэмшихэд энэ “Адуучин” тэмцээн чухал ач холбогдолтой. Бидний бахархал болсон энэ соёл, уламжлалыг олон нийтэд сурталчилж, хүртээл болгох үүднээс ирэх жилээс энэ тэмцээнийг Үндэсний их баяр наадмын хөтөлбөрт оруулах болсон гэж Ерөнхий сайд Н.Алтанхуяг тэмцээнд оролцогчдод хандаж хэллээ. Аймаг бүрээс шалгарч ирсэн шилдэг адуучдаас Хэнтий аймгийн Биндэр сумын адуучин Х.Бат-Эрдэнэ шилдгийн шилдгээр шалгарч Ерөнхий сайдаас шагналаа гардлаа. Удаах байранд өнгөрсөн жилийн аварга Хэнтий аймгийн Батноров сумын адуучин А.Алтаншагай, гурав дугаар байранд Архангай аймгийн Цэнхэр сумын адуучин Ч.Баасандорж нар шалгарлаа. Мөн тэмцээний төрөл тус бүрээр аварга шалгаруулж шагнал гардуулсан байна. Тэмцээний нийлбэр дүнгээр тэргүүн байранд орсон адуучин 8 сая төгрөгөөр шагнуулсан бол дэд байр 6 сая төгрөг, гуравдугаар байрын шагнал 4 сая төгрөг байлаа. Тэмцээний үеэр адуучны эдлэл хэрэглэлийн үзэсгэлэн худалдаа, үндэсний хувцасны загварын үзүүлбэр зэрэг арга хэмжээнүүд зохиогдлоо.





Монголын үндэсний спортын V-р их наадам 2014 оны 09 дүгээр сар 10-13

Монгол улсын Засгийн газрын 2014 оны 13 тоот тогтоолоор Үндэсний спортын Их наадмын I шатны тэмцээнүүд аймаг, дүүргийн хэмжээнд энэ оны 02 дугаар сараас эхлэн орон даяар, II шат буюу шигшээ тэмцээнийг 09 дүгээр сарын 12-14-ны өдрүүдэд Хүй долоон худагт амжилттай зохион байгуулан явууллаа. Үндэсний спортын V Их наадамд 21 аймаг, 9 дүүрэг, тусгай зэрэг 35 байгууллагын 3000 гаруй тамирчид хамрагдан оролцлоо.

Их наадмын үндэсний бөхийн барилдаанд нийслэл хотод төвлөрч байгаа бөхчүүдийн дунд "Нутгаа дуурсгана" барилдааныг улсын цолтон, аймгийн цолтон, сумын цолтны ангиллаар, хөдөө орон нутагт ажиллаж амьдарч байгаа бөхчүүдийн дунд "Хөдөөгийн хүчтэн" барилдааныг явууллаа. Улсын цолтны ангилалд 18 аймгийн 12 дэвжээ, аймгийн цолтны ангилалд 18 дэвжээ, сумын цолтны ангилалд мөн 18 дэвжээ гурван хэсэгт хуваагдан хоорондоо тойргоор барилдав.

Сумын цолтны ангилалд:

1. Булган аймгийн Булганхангайн хүчтэн дэвжээ
2. Засагт ханы Завхан дэвжээ
3. Ховд аймгийн Ховд дэвжээ

"Хөдөөгийн хүчтэн" үндэсний бөх: 21 аймгийн 105 бөхчүүд тойргоор барилдаж багийн дүнгээр: 1-р байранд аймгийн заан Э.Саранбаатар ахлагчтай Сэлэнгэ аймгийн бөхчүүд, 2-р байранд аймгийн арслан Б.Мөнхбаяр ахлагчтай Увс аймгийн бөхчүүд

3-р байранд аймгийн арслан Б.Уртбаяр ахлагчтай Орхон аймгийн бөхчүүд



Уран уургач, бүгуйлч, эмнэг булгиулалт: 18 аймаг 3 дүүрэг, хүчний 2 байгууллага нийт 23 байгууллагын 92 тамирчид оролцлоо.

Уран уургачын төрөлд:

- 1 дүгээр байр Булган аймаг Н. Даваадорж
- 2 дугаар байр Баянхонгор аймаг Т. Доржбат
- 3 дугаар байр Дархан-Уул аймаг Г. Энхбаатар

Эмнэг булгуулагч :

- 1 дүгээр байр Өвөрхангай аймаг Ц. Эрдэнэчулуун
- 2 дугаар байр Хилчин БТСХороо А. Мягмарсүрэн
- 3 дугаар байр Дорнод аймаг М. Отгонбаяр

Бүгуйл:

- 1 дүгээр байр Хөвсгөл аймаг Ц. Мягмарсүрэн

Байгууллагын нэгдсэн дүнгээр Говьсүмбэр аймаг, Дархан-уул аймаг, Булган аймгууд түрүүлээ.



Үндэсний сурын харваа

Багийн харваа:

- 1-р байр: Орхон аймгийн баг: - МУГТ, Даяар дуурсагдах мэргэн Ш.Даваахүү
- 2-р байр: Алдар спорт хорооны “Алдар-жем” баг: - Б.Баярсайхан
- 3-р байр: Багануур дүүргийн баг: - Спортын мастер Г.Амарсайхан

Цуваа харваа эрэгтэй:

1. Алдар БТСХ-ны “Алдар Жем” багийн харваач Спортын мастер Б.Батбаяр
2. Орхон аймгийн Хангарьд СХ-ны харваач СМ А.Энхтөр
3. Орхон аймгийн Хангарьд СХ-ны харваач МУ-ын гоц мэргэн Л.Отгонбаяр

Эмэгтэй:

1. Налайх дүүргийн “Шинэ Налайх” ХХК-ийн харваач МУ-ын мэргэн Г.Батзаяа
2. Орхон аймгийн Хангарьд СХ-ны харваач СМ М.Мөнх-Амгалан
3. Алдар БТСХ-ны “Алдар Жем” багийн харваач МУ-ын мэргэн Д.Норжмаа

Уламжлалт харваа: 8 багийн 80 харваачид оролцлоо.

- Эрэгтэй: 1-р байр Ц.Эхчулуун /Баянзүрх дүүрэг/
 - 2-р байр Б.Үнэнбат /Алдар БТСХ/
 - 3-р байр С.Ариунбат /Сонгинохайрхан дүүрэг/
- Эмэгтэй: 1-р байр М.Батгэрэл /Төв аймаг/
 - 2-р байр Д.Цэцэг /Чингэлтэй дүүрэг/
 - 3-р байр Өлзий-Орших /Сонгинохайрхан дүүрэг/
- Баг: 1-р байр Орхон аймгийн баг: - Г.Хүрэлбаатар

- 2-р байр Алдар БТСХ-ны “Алдар-жем” баг - С.Энхтунгалаг
- 3-р байр Дархан-Уул аймгийн баг - Л.Болормаа

Буриад сурын харваа: 12 багийн 145 гаруй тамирчид харваачид оролцлоо.

- 1-р байранд Дорнод аймгийн хүндэт мэргэн Г.Ломбодорж ахлагчтай “Дорнод I” баг
- 2-р байранд Ц.Хүдэрчулуун ахлагчтай Баянзүрх дүүргийн “Бурхан халдун” группын баг
- 3-р байранд Спортын мастер Х.Баасанхүү ахлагчтай Орхон аймгийн “Хангарьд” группын баг

Цуваа харваа /эрэгтэй/:

1. Дорнод аймгийн Баяндун сумын “Аш авгад” ХХК-ийн харваач О.Сүхбаатар
2. Дорнод Дашбалбар сумын Б.Базар /Спортын дэд мастериин болзол хангасан/
3. Дорнод Сэргэлэн сумын МУ-ын мэргэн З.Ариунбат

Эмэгтэй:

1. Өмнөговь аймгийн “Таван толгой транс”-ийн харваач М.Саранзаяа /Спортын дэд мастериин болзол хангасан/
2. Дорнод аймгийн Дашбалбар сумын харваач Э.Оюунжаргал
3. “Тэс” группын “Алтан дуулга” ХХК-ын харваач МУ-ын мэргэн Ж.Нямдаваа

Урианхай сурын харваа: 9 багийн 108 харваачид оролцлоо.

- Баг: 1-р байр МУ-ын хошой мэргэн Б.Мөнхтөр ахлагчтай Налайх дүүргийн баг
- 2-р байр Спортын мастер С.Чимэддорж ахлагчтай Орхон аймгийн баг
- 3-р байр Спортын мастер Ж.Баян-Өлзий ахлагчтай Сэлэнгэ аймгийн баг
- Цуваа: 1-р байр Хэнтий аймгийн Баянхутаг сумын харваач Ж.Энх-Амгалан
- 2-р байр Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын харваач С.Дүгэржав
- 3-р байр Зэвсэгт хүчний Алдар спорт хорооны харваач Б.Хатансайхан

Шагайн харваа: төрөлд 36 багийн 320 гаруй харваачид өрсөлдлөө.

- 1-р байр Сэлэнгэ аймгийн баг - Аймгийн гоц мэргэн Б.Болд
 - 2-р байр Төв аймгийн баг - МУ-ын Үлэмж дархан мэргэн Ц.Энхбат
 - 3-р байр Баянхонгор аймгийн баг - Аймгийн гоц мэргэн Ж.Батмөнх
- Ширээний шагай:** 17 аймаг, 7 дүүрэг, АлдарСХороо зэрэг 26 багийн 127 буюу давхардсан тоогоор 420 гаруй тамирчид оролцлоо.

- Багийн төрөлд: 1-р байр Баянхонгор аймгийн баг
 - 2-р байр Чингэлтэй дүүргийн баг
 - 3-р байр Багахангай дүүргийн баг

- Ганцаарчилсан төрөлд эрэгтэй /насанд хүрэгчид/:
- Я.Базарсүрэн (Сонгинохайрхан дүүрэг)
- Ганцаарчилсан төрөлд эмэгтэй /насанд хүрэгчид/:
- Н.Эрдэнэгэрэл (Баянхонгор аймаг)

Хөвгүүд:

- С.Жадамбаа (Баянхонгор аймаг)
- Охид:
- Ц.Саранцэцэг (Багануур дүүрэг)

Цуваа харваа: 1-р байр Т.Баасанхүү /Архангай аймаг “Хүннү” дэвжээ/

Талын харваа: 1-р байр МУ-ын мэргэн Д.Батсайхан /Хан-Уул дүүрэг/

Шилдэг дэвжээ:

- Т.Ганболд дасгалжуулагчтай Архангай аймгийн “Хүннү” дэвжээ
- Г.Ганбаатар дасгалжуулагчтай Архангай аймгийн “Алтан Овоо” дэвжээ
- Р.Эрдэнэбаатар дасгалжуулагчтай Архангай аймаг “Батцэнгэл” дэвжээ

Их наадмын хүрээнд зохион байгуулагдсан **жороо морины** уралдаанд нийт 21 жороо морьд уралдлаа.

- 1-р байр Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын 5-р багийн С.Мөнхбаярын зүрхэн тамгатай хар алаг морь
- 2-р байр Сэлэнгэ аймгийн Баруун бүрэн сумын А.Эрдэнэбүрэнгийн хар морь
- 3-р байр Сэлэнгэ аймгийн Мандал сумын Арвины хээр морь тус тус шалгарлаа.



Морин поллогийн үзүүлэх тоглолтод Өвөрхангай аймгийн Хужирт сумаас 2 баг, Дорноговь аймгийн Сайхандулаан сумын 1 баг, Зэвсэгт хүчний 232-р ангийн 1 баг оролцлоо.

Шилмэл мал 2014 үзэсгэлэн

Үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарын энэ жилийн “Намрын ногоон өдрүүд-2014” нэгдсэн арга хэмжээний хүрээнд үржлийн шилмэл мал шалгаруулах, үнэ хаялцуулан худалдаалах, өндөр ашиг шимтэй мал, амьтныг сурталчлан олон

нийтэд таниулах зорилго бүхий “Шилмэл мал-2014” арга хэмжээ энэ сарын 12-ноос 14-ний өдрүүдэд “Хүй долоон худаг” дахь “Монгол наадам цогцолбор”-т зохион байгуулагдсан.

Энэхүү арга хэмжээний үеэр Монгол улсад үржүүлж буй үржлийн шилмэл малыг шалгаруулан, үнэ хаялцуулах дуудлагаар худалдаалахын зэрэгцээгээр гэрийн тэжээвэр амьтад болон монгол нохойн үзэсгэлэн, үндэсний дээл, хувцас, мал аж ахуйн тоног хэрэгсэл, ном товхимол, малын тэжээл, эм бэлдмэл, цагаан идээний үзэсгэлэн худалдаа гарсан.

Энэ жилийн үзэсгэлэн яармагт Бүгд Найрамдах Франц Улсаас 20-иод аж ахуй нэгж урилгаар оролцсон.





2014 оны баяр, наадмын төсөв, хэрэглэгдээгүй зардал

№	Үйл ажиллагааны нэрс	Огноо	Хамтран ажиллах байгууллага	Төсөв	Тайлбар
1	Монгол наадам цогцолборын танилцуулга, макетны үнэ	7 сар	Монгол Наадам Цогцолбор ОНӨТҮГ	19,090.0	Цогцолборын ерөнхий төлөвлөгөө батлагдаагүй учир макет хийлгэх боломжгүй
2	Дэлхийн адууны баяр	8 сар	Монголын морин спорт уяачдын холбоо	21,113.6	Дэлхийн адууны холбооноос Монголд болох адууны баярыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан
3	Монголын бурханы шашин соёлын "СОЁМБО" наадам -3	9 сар	ССАЖЯ МБШТөв Гандантэгчилэн хийд	44,300.0	Монголын бурхны шашинтны төв Гандантэгчилэн хийд хайлангийн хурлаа сэрүүн орсон үед 10 сард хийсэн учир СОЁМБО наадмыг зохион байгуулах боломжгүй болсон.
4	ЦАС, МӨСНИЙ ХОТХОН /нээлтийн арга хэмжээ/	12 сар 20	НЗДТГ	109,140.0	
	НИЙТ ДҮН			193,643.6	